



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№113 /113/ 2021.08.16

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

АЯНЫ БОГЦ

МОНГОЛ ДАЙЧИД БЭЛТГЭЛЭЭ ЧАМБАЙРУУЛСААР БАЙНА



Олон улсын "Аравт" морин цэргийн уралдаанд оролцох Монгол Улсын Зэвсэгт хүчний баг тамирчид тэмцээн зохион байгуулагдах газар болох ОХУ-д энэ сарын 11-нд очсон. Уралдааны бэлтгэл сургуулилтаа манай баг тамирчид сайн хангаж дууссан хэдий ч гаднын мориор танихгүй газар оронд уралдахад хүндрэлтэй тул үлдсэн 10 гаруй хоногийн хугацаанд морьдтойгоо дотносох, ижилсэх, морьдоо маллах зэрэг ажлуудад ханцуй шамлан ороод байна. Энэ жилийн тэмцээнд ОХУ, Монгол, Казахстан, Узбекистан

Улсын цэргийн алба хаагчид хурд, хүч, авхаалж, самбаагаа сорих бөгөөд өнгөрсөн Бямба гарагт Монгол, Казакстан, Узбекистан Улсын цэргийн алба хаагчид унах морьдоо сугаллаа. Харин ОХУ-ын баг тамирчид энэ удаагийн сугалаанд оролцолгүй өөрсдийн шилэгдмэл удмын морьдтой тэмцээнд оролцох аж.

Сугалааны оноолтоор манай багт тоомсог голдуу морьд таарсан бөгөөд тэдний дунд ганц хөөрхөн монгол халиун морь таарсныг "Хөөрхөн халиун" хэмээн өхөөрдөн нэрлэжээ. Түүнчлэн

цэргийн авторалли тэмцээнд оролцох баг 1 дүгээр сугалааг сугалсан бөгөөд машин техникээ хүлээн авч, тэмцээний бэлтгэлээ хангаж эхлээд байна.

Тус тэмцээний шүүгчдийн бүрэлдэхүүнд ЗХЖШ-ын Материал техникийн газрын орлогч дарга, техникийн хэлтсийн дарга, хурандаа Ц. Төрмөнх, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, ЗХЖШ-ын Сургалтын бодлого зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, биеийн тамир спортын тасгийн дарга, хурандаа Д. Цог-Эрдэнэ нар багтаж байгаа

юм Ташрамд сонирхуулахад Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид Оросын Холбооны Улсын Зэвсэгт хүчний Төв цэргийн тойргийн ерөнхий цэргийн 41 дүгээр армийн Тавин тавдугаар мотобуудлагын уулын бригаданд байрлаж байгаа юм. Монгол Улсын Зэвсэгт хүчний баг тамирчдыг ЗХЖШ-ын АУГ-ын дарга, бригадын генерал С.Дашзэвэг ахалж яваа бөгөөд тэрээр баг тамирчдынхаа бэлтгэл сургуулилтад байнгын хяналт тавихаас гадна удирдлагын зүгээс үзүүлэх бүхий л талын дэмжлэг



УЛААНБААТАРТ 27-29 ХЭМ ДУЛААН БАЙНА

Малчид, иргэдийн анхааралд: Өнөөдөр баруун аймгуудын нутгаар, 17-нд нутгийн баруун хагаст үргэлжилсэн бороо орж, зарим газраар ахиухан хэмжээний бороо орохыг анхааруулж байна.

2021 оны 8 дугаар сарын 16-ны 08 цагаас 20 цаг хүртэл: Нутгийн баруун хагаст үүлэрхэг, бусад нутгаар солигдмол үүлтэй. Баруун аймгуудын ихэнх нутаг, төвийн аймгуудын нутгийн баруун хэсгээр бороо, дуу цахилгаантай аадар бороо орно. Салхи баруун аймгуудын нутгаар баруун

хойноос, бусад нутгаар баруун өмнөөс секундэд 5-10 метр, зарим газраар борооны өмнө түр зуур ширүүснэ. Алтай, Хангай, Хөвсгөлийн уулархаг нутаг, Завхан голын эх, Хүрэнбэлчир орчим, Идэр, Тэс голын хөндийгөөр 17-22 хэм, Орхон-Сэлэнгийн сав газар болон говийн бүс нутгийн өмнөд хэсгээр 29-34 хэм, бусад нутгаар 24-29 хэм дулаан байна.

Улаанбаатар хот орчмоор: Үүлшинэ. Бороо орохгүй. Салхи баруун өмнөөс секундэд 6-11 метр. 27-29 хэм дулаан байна.

Багануур орчмоор: Үүлшинэ. Бороо орохгүй. Салхи баруун өмнөөс секундэд 6-11 метр. 25-27 хэм дулаан байна.

Тэрэлж орчмоор: Үүлшинэ. Бороо орохгүй. Салхи баруун өмнөөс секундэд 6-11 метр. 25-27 хэм дулаан байна.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 183,591 +1300	ЭДГЭРСЭН 167,173 +1657	НАС БАРСАН 876 +4
-----------------------------------	---------------------------	----------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4333 +78	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 162 +4	ЭДГЭРСЭН 4088 +16
-----------------------------	-------------------------------	----------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 207,946,051
Эдгэрсэн Нийт: 186,402,880
Нас барсан Нийт: 4,374,253

КОВИД-19

Өвдөөд эдгэрсэн таны, миний хайртай хүмүүс нийгмийн гадгуурхалд өгөх ёстой!

КОВИД-19-өөр өвдсэн хүмүүсийг нийгмийн гадгуурхалд болж, сэтгэлийн түгшүүр, бүхмилдэл & цочролд ордог.

Өвдөөд эдгэрсэн хүмүүсийг ялгаруулан гадгуурхах нь ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСЛЭЛГҮЙ & ХҮНЛЭГ БҮС зүйл юм.

КОВИД-19-өөр өвдөөд эдгэрсэн хүнтэй харилцах нь АЮУЛГҮЙ бөгөөд буддыг ХАЛДВАРЛУУЛАХГҮЙ.

Эдгэрсэн хүн вируссын калдварыг ДАМЖУУЛДАГГУЙ болж шинжлэх ухаанаар баталсан.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 25	🌧️ 13
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 32	🌧️ 24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.850.0	2.853.0
EUR 🇪🇺	3.50.0	3.360.0
CNY 🇨🇳	440.0	441.0
RUB 🇷🇺	38.20	39.40
JPY 🇯🇵	25.58	26.02
KRW 🇰🇷	2.42	2.51

ЗУРХАЙ

2021.08.16 ДАВАА ГАРАГ
/БИЛГИЙН ТООЛЛЫН 8/

НАМРЫН ТЭРГҮҮН УЛААН БИЧ САРЫН ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ УЛААН БИЧ ӨДӨР

Үс засуулбал:
Нас уртасна
Наран ургах, шингэх:
05:49-20:04
Барилдлага:
Идэр
Шүтэн барилдлага:
Тийн мэдэхүй
Суудал:
Ус
Энэ өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой.
Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, таенай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрмөс татвал үг, асуулт болно.

ДОРНЫН ЗУРХАЙ: Үс засуулбал нас уртасна

ЦАХИМ ШУУДАНД

ХАНДИВЫН АЯН ХҮҮХДИЙН БАЯР ХӨӨРӨӨР ҮРГЭЛЖИЛЛЭЭ



БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын мандаттай "UNMISS" энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний 10 дугаар ээлжийн батальоны бие бүрэлдэхүүн Бентью суурины төв эмнэлэгт хандив өгсөн тухай өмнө мэдээлсэн билээ. Тэгвэл тус хандивын аян нь 1000 гаруй хүүхэд багачуудын дуу цангинасан Бентью суурины бага сургуулийн сурагчдад мөн хүрч, батальоны бие бүрэлдэхүүн 100

хүүхдийн хичээлийн хэрэгсэл, 300 ширхэг тоглоом, 9000 ширхэг амны хаалт, 100 литр гар ариутгагчийг цуглуулан гардуулж өгсөн юм. Хандивын арга хэмжээнд батальоны удирдлага, эмэгтэй энхийг сахиулагчдын төлөөлөл болон Бентью суурины бага сургуулийн багш, сурагчид оролцов. Тус сургуулийн удирдлага, багш нар батальонд хандан "Цар тахлын үед манай сургуулийн сурагчдад туслан хандив өгсөн явдалд сургуулийн нийт

сурагчид, багш нарынхаа өмнөөс баярлалаа. Та бүхэнд сайн сайхан бүхнийг хүсье" хэмээн талархлаа илэрхийллээ. Ташрамд БНӨСУ-ын нийт хүн амын 27 хувь нь бичиг үсэг мэддэг, нийт эмэгтэйчүүдийн 16 хувь нь бичиг үсэг мэддэг гэсэн судалгаа байдаг бөгөөд нийт хүн амын боловсролын түвшнээрээ дэлхийд доогуурт тооцогддог улс орны нэг юм.

Ахлах дэслэгч Г.ЦЭРЭННАДМИД

"ЭР ЦЭРГИЙН АЛБА-АМЬДРАЛЫН ИХ СУРГУУЛЬ" СЭДЭВТ УРЛАГИЙН ТОГЛОЛТОО СОНИРХУУЛЛАА

2021 оны 5 дугаар сараас эхлэн ангийн захирагчийн тушаалаар Зенитийн артиллерийн дивизионы хугацаат цэргийн алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, нэгнээсээ суралцаж, нэгэндээ зааж зааварлах, нөхөрлөлийг бататгах, суралцах хүсэл эрмэлзлэлийг нь нэмэгдүүлэх өөрсдийгөө бие даан хөгжүүлэхэд нь туслах зорилгоор англи хэл, солонгос хэл, илтгэх урлаг, уран зураг, гитар зэрэг 8 төрлийн дугуйланг

хичээллүүлж эхэллээ. Хугацаат цэргийн алба хаагчид энэхүү хугацаанд сурч мэдсэн зүйлсээ дивизионы офицер, ахлагч нартайгаа хамтран ангийн бие бүрэлдэхүүнд тайлан тоглолтоо сонирхууллаа. Мөн энэхүү тоглолтыг иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, ангийн үйл ажиллагааг хугацаат цэргийн алба хаагчдын ар гэрийнхэнд нь сурталчлах, цэргийн алба хаагчидтай холбоотой мэдээ, мэдээллээр хангах зорилгоор нээсэн "Facebook хаалттай групп"-т

шууд "live" хийн ар гэрийнхэнд нь мөн адил үзүүлж сонирхуулсан юм. Тоглолтын нээлтийн эхэнд байлдагч М.Доржсамбуу "Эр цэргийн алба-Амьдралын их сургууль" сэдвээр илтгэл тавьж, англи, солонгос хэлний дугуйлангийн байлдагч нар өөрсдийн суралцаж буй хэлээр дуулж, гитарын дугуйлангийн суралцагч нар өөрсдийн бэлтгэсэн урлагийн номерыг үзүүлсэн юм. **Ахмад Л.ТҮМЭНДЭЛГЭР**



УЛААНБААТАР ХОТОД ӨНӨӨДӨР 4969 ИРГЭНИЙГ ДАРХЛААЖУУЛНА

Улаанбаатар хотод өнөөдөр суурин 39 цэгт 47 багийн 324 эмч, ажилтан

ажиллаж, 4969 иргэнийг дархлаажуулна. Дархлаажуулалтын цэгүүдийг дүүрэг тус бүрээр танилцуулж байна.

Шинжилгээний болон дархлаажуулалтын цэгүүдийг дүүрэг тус бүрээр танилцуулж байна.

15 БАЙРШИЛД ХҮНСНИЙ НОГООНЫ ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА ГАРЧЭЭ



Нийслэлийн хүн амыг эх орны хөрсөнд ургасан төмс, хүнсний ногоогоор хангах, хангамж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, дархлааг дэмжих зорилгоор Нийслэлийн Засаг дарга "Алтан намар" төмс, хүнсний ногооны үзэсгэлэн худалдаа зохион байгуулахыг холбогдох албаныханд үүрэг болгосон. Энэ дагуу Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаалаар нийслэлийн 9 дүүргийн 24 байршилд төмс, хүнсний ногооны үзэсгэлэн худалдаа зохион байгуулахаар ажиллаж байна.

Тэгвэл одоогийн байдлаар нийт 15 байршилд хүнсний ногоо эрхлэгчид ногоогоо борлуулж байна. Тухайлбал, Сүхбаатар дүүрэгт тав, Баянзүрх дүүрэгт гурав, Баянгол, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт тус бүр хоёр, Багануур дүүрэгт нэг цэг ажиллаж байна. Баянгол дүүрэгт 1000 машины зогсоолын зүүн, баруун талд ногооны үзэсгэлэн, худалдаа зохион байгуулж байгаа бөгөөд "Улаанбаатар төмөр зам" ХНН-ээс тодорхой хариу өгөхгүй байсны улмаас хугацаа алджээ. Иймээс Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөр, "Улаанбаатар төмөр зам" ХНН болон дүүргийн удирдлагууд газар дээр нь ажиллаж, асуудлыг шийджээ. Улмаар нэг ногоочинд 16 ам метр талбай ноогдох байдлаар 170 орчим ногоочинд

хүнсний ногоогоо борлуулах боломжийг олгожээ. Зарим аймгаас ногоочид ирээгүй байгаа бөгөөд үлдсэн байршилд ногоог борлуулах зохицуулалт хийсэн байна. Үзэсгэлэн худалдааг зохион байгуулахад УОК-ын даргын "Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам" болон "Алтан намар" арга хэмжээний хүрээнд төмс, хүнсний ногооны үзэсгэлэн худалдаа зохион байгуулахад мөрдөх "Түр заавар"-ыг мөрдлөг болгоно. Ингэхдээ дүүрэг бүрийн Засаг даргын дэргэдэх Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, үйл ажиллагаанд дотоод хяналт тавих иргэн, хуулийн этгээдийг худалдаа эрхлэгчдийн төлөөлөөс сонгон, гэрээ байгуулж байгаа юм.

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИСС

UB ХАМТДАА

2021.08.16-08.20-нд АЖИЛЛАХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЦЭГИЙН БАЙРШИЛ

Д/Д	ДҮҮРЭГ	ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ГАЗАР	БАЙРШИЛ	НЭГ ӨДӨРТ АВАХ ШИНЖИЛГЭЭНИЙ ТОО
1	Баянгол	Эмүжин төв	Өргөө кино театрын урд байрлах Петровис ШТС-ын баруун урд талд, Хөгжил хотхоны урд	150
2	Сүхбаатар	СБД-ийн ЭМТ-ийн нэг цэгийн үйлчилгээ	100 айл, Жоби төвийн зүүн талд	120
3	Чингэлтэй	ЧД-ийн ЭМТ-ийн нэгдсэн эмнэлэг	СУИС-ын замын урд ЧД-ийн нэгдсэн эмнэлгийн хашаан дотор	100
4	Баянзүрх	Шинжилгээ авах явуулын баг	Баянзүрх дүүргийн Авто оношлогооны төвийн зогсоол	100
5	Сонгинохайрхан	Шинжилгээ авах явуулын баг	5 шарын төмөр замын гарамын урд байрлах Номин агуулах байрны гадаа	150
6	Хан-Уул	Шинжилгээ авах явуулын баг	Буянт-Ухаа спорт цогцолборын гадаа талбай	100

09:00-12:00 ЦАГИЙН ХООРОНД ТҮРГЭВЧИЛСЭН ШИНЖИЛГЭЭ АВНА

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ЭНЭ САРЫН 15-23 НЬ ХҮРТЭЛ ХӨЛ ХОРИО ТОГТООЛОО

Баян-Өлгий аймгийн хэмжээнд коронавируст халдвар /ковид-19/-ын тохиолдлын тархалт улсын дунджаас өндөр, мөн мэргэжлийн байгууллагуудын салбар дундын багийн хийсэн тав дахь удаагийн эрсдэлийн үнэлгээгээр хүн амын дунд тархах халдварын эрсдэл "Маш өндөр эрсдэлтэй" гэж үнэлэгдсэн байна.

Иймд тус аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн хэмжээнд 2021 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн өглөөний 06.00 цагаас эхлэн

8 дугаар сарын 24-ний өдрийн 23.00 цаг хүртэлх хугацаанд олон нийтийг хамарсан үйл ажиллагааг түр зогсоож, нийслэл болон бусад аймгаас

ирэх хөдөлгөөнийг хаахаар шийдвэрлэжээ.

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газар



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)